



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 351

Улаанбаатар хот

“Би Би Эс Эс” ХХК-ийн
тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29.2 дахь заалт болон Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Би Би Эс Эс” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.
2. Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Би Би Эс Эс” ХХК /М.Баасандорж/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН